



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 03 өдөр

Дугаар А/220

Сүхбаатар сум

Г Аймгийн Засаг даргын 2020 оны А/212 дугаар захирамжид нэмэлт өөрчлөлт оруулж, хугацаа сунгах, зарим газрын үйл ажиллагааг нээх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", "ж", "л", 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.6, 39 дүгээр зүйлийн 39.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, 32.1.12, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн "Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай" 01 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын хурлын 2020 оны 07 дугаар сарын 1-ний өдрийн 25 дугаар хурлын тэмдэглэл, 07 дугаар сарын 28-ны өдрийг 27 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхий нийтэд коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын тархалт буурахгүй байгаатай холбогдуулан түүнээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд "Аймгийн Засаг даргын 2020 оны А/212 тоот захирамжийн 1 дэх заалтын "7 дугаар сарын 31-ний" өдөр хүртэлх гэснийг өөрчилж, гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг "2020 оны 8 дугаар сарын 31-ний" өдрийг дуустал сунгасугай.


2. Хувийн хэвшлийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих зорилгоор жагсаал цуглаан, нийтийг хамарсан спорт үйл ажиллагаа, цахим тоглоомын газар, диско болон бүжгийн баарнаас бусад бүх төрлийн хүүхдийн тоглоомын газар, баар, биллиард, шашин, соёл урлаг, үзвэр үйлчилгээний газрын үйл ажиллагааг халдвар хамгааллын дэглэмийг Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/249 дүгээр тушаалаар батлагдсан журмын дагуу чанд мөрдүүлэн үе шаттайгаар нээхийг сумдын Засаг дарга нарт зөвшөөрсүгэй.

3. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээг эрчимжүүлэх, иргэд, олон нийтэд сурталчлах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, халдвар, хамгааллын дэглэм, зөвлөмжийг мөрдүүлэн, төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг нэмэгдүүлж, болзошгүй үер усны аюул, нийтийг хамарсан халдварт өвчний дэгдэлтээс урьдчилан сэргийлэх, нүхэн жорлонг ариутгах, халдваргүйжүүлэх зэрэг ажлуудыг зохион байгуулахыг төр, хувийн хэвшлийн байгууллагуудын удирдлага, сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

4. Бүх шатны сургалтын байгууллагын 2020-2021 сны хичээлийн жилийн үйл ажиллагааг үе шаттай эхлүүлэх бэлтгэл ажлыг хангуулан явцын мэдээллийг аймгийн Онцгой комиссын хуралдаанд танилцуулахыг аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын дарга Ч.Жаргалсайханд даалгасугай.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, хурандаа /А.Энхбат/, Мэргэжлийн хяналтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Баттүвшин/, Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа /Б.Энхбаатар/, сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ